



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

2020.09.02 № 03/08-УВА-2020/05/НА  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Ж.Буян-Оршихын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Увс аймаг дахь Төрийн аудитын газар нь Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Өмнөговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор бие даан нэр дэвшигч Ж.Буян-Оршихын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3. дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

0209261674

Бие даан нэр дэвшигч Ж.Буян-Оршихын мөрийн хөтөлбөр  
/...../ хуудас/-ийг хавсаргав.

Хавсралт . . 2 . хуудастай

Хувийг: Увс аймгийн Өмнөговь сумын Сонгуулийн хороонд

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТЦУУРЬ/

ХЯНАСАН:  
АУДИТЫН МЕНЕЖЕР

 /М.БАТ-АМГАЛАН/

БОЛОВСРУУЛСАН:  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

 /Т.НАМЖИЛ/  
/Ч.МӨНХТОГТОХ/